

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБОГДСОН НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүн, тодруулбал бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хийг импортлох, бөөнөөр, жижиглэнгээр худалдах /борлуулах/ тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэдээ тайлан гаргах харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Барилгын тухай, Галын аюулгүй байдлын тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудад нийцсэн байна.

Хоёр. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ

2.1 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан зүйлийг тусгана.

2.2 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийг дараах төрлөөр олгоно. Үүнд:

2.2.1. Импортлох /Автобензин, дизелийн түлш, агаарын хөлгийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хий, жижиглэн савласан (220-500 гр) газрын тосны шингэрүүлсэн хий, хийн конденсат, керосин, нафта /;

2.2.2. Бөөний худалдаа /Автобензин, дизелийн түлш, агаарын хөлгийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хий, жижиглэн савласан (220-500 гр) газрын тосны шингэрүүлсэн хийг бөөнөөр худалдаалах/;

2.2.3. Жижиглэнгийн худалдаа /Автобензин, дизелийн түлшийг шатахуун түгээх станцаар, шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хийг автомашин цэнэглэх станцаар болон баллоноор худалдаалах/;

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах

3.1 Аж ахуйн нэгж (Монгол улсад бүртгэлтэй) тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө энэхүү журмын дөрөвт, тусгай зөвшөөрлийг сунгуулах өргөдлөө энэхүү журмын тавд заасан материалын хамт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагад гаргана. Энэхүү журмын зургаад заасан материалыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

3.2 Тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг газрын тосны асуудал эрхэлсэн сайдын тушаалаар шийдвэрлэнэ. Сайдын тушаалд заасны дагуу холбогдох тэмдэглэгээг тусгай зөвшөөрлийн асуудал эрхэлсэн яамны Төрийн нарийн бичгийн /газрын/ дарга гарын үсэг зурж албажуулна.

3.3 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өргөдөл гаргасан хуулийн этгээдийн агуулах, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техникийн дүгнэлтийг ажлын 20 хоногийн дотор гаргана.

3.4 Хэрэв шаардлагатай гэж үзвэл 3.3-т заасан хугацааг ажлын 10 хоногоор сунгаж болно.

3.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн агуулах, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техникийн дүгнэлтийг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр бүртгэлийн гэрчилгээг олгоно. Бүртгэлийн гэрчилгээ олгосон аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар мэдээллэнэ.

3.6 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц болон автомашин хийгээр цэнэглэх станцын бүртгэлийн гэрчилгээнд түүнийг олгосон он, сар, өдөр, дугаар, хүчинтэй хугацаа, эзэмшигчийн нэр, байршил, хүчин чадал, бүтээгдэхүүний төрлийг тэмдэглэсэн байна.

3.7 Хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, иргэний материалыг судлан газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техник технологийн байдалтай танилцаж, санал дүгнэлт гаргах үйл ажиллагааны зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал

4.1. Импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.2. Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд байх.

4.1.3. Газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гарал үүслийн гэрчилгээ /эх хувь, баталгаат орчуулгын хамт/.

4.1.4. Өөрийн эзэмшлийн агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар,

4.1.5. Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн баталгаажуулсан хуулбар,

4.1.6. Өөрийн хэрэгцээнд импортлох бол энэ журмын 4.1.4 дүгээр заалт хамаарахгүй.

4.1.7. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон агуулахын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.8. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техникийн дүгнэлт /эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар/;

4.2. Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.2.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ,

4.2.2 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.10.б-д заасан холбогдох хураамжийг төлсөн баримт;

4.2.3 Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, эсхүл түрээсийн гэрээний эх хувь;

4.2.4 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон агуулахын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.2.5 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулах (түрээсийн гэрээнд заагдсан агуулах)-д гаргасан техникийн дүгнэлт /эх хувь эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар/;

4.2.6 Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд байх.

4.3. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.3.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

4.3.2. Холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээд байх.

4.3.3. Түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түгээх станцын түрээсийн гэрээ эх хувь;

4.3.4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээний хуулбар, техникийн дүгнэлтийн эх хувь;

4.3.5. Шингэрүүлсэн шатдаг хийг баллоноор жижиглэнгийн худалдаа эрхлэгчийн хувьд:

4.3.5.1 Баллон хадгалах завсрын агуулахын үл хөдлөхийн гэрчилгээ нотариатаар баталгаажуулсан хуулбар, эсвэл түрээсийн гэрээ эх хувь;

4.3.5.2 Онцгой байдлын газраас олгосон Галын аюулгүй байдлын зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар,

4.3.5.3 Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон ажлын байрны дүгнэлтийн нотариатаар баталгаажуулсан хуулбар,

4.3.5.4 Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний эх хувь, хуулбарын хамт.

Тав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад бүрдүүлэх материал

Хугацаа сунгуулах өргөдлийг холбогдох материалын хамт тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.1 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

5.1.1 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл;

5.1.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байсан талаарх газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

5.1.3 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

5.2 Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарч дараах материалыг нэмж бүрдүүлнэ. Үүнд:

5.2.1 Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний эх хувь, нотариатаар баталгаажуулсан хуулбар,

5.2.2 Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ /баталгаажуулсан хуулбар/, техникийн дүгнэлт;

5.2.3 Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний эх хувь, баталгаажуулсан хуулбар, техникийн дүгнэлт.

Зургаа. Агуулах, шатахуун түгээх станцын техникийн дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх материал

6.1. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн агуулахын техникийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтыг /эх хувиар эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар/ бүрдүүлнэ. Үүнд:

6.1.1. Техникийн дүгнэлт гаргуулах хүсэлт;

6.1.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

6.1.3. Стандартын шаардлага хангасан агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;

6.1.4. Агаарын хөлгийн шатахууныг хадгалах зориулалтын агуулахад Иргэний нислэгийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт;

6.1.5. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдын судалгаа;

6.1.6. Агуулахын газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторийн судалгаа эсвэл итгэмжлэгдсэн лабораторитай байгуулсан гэрээ;

6.1.7. Галын аюулгүй байдлын зөвшөөрөл;

6.1.8. Мэргэжлийн байгууллага боловсруулж улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших гэрчилгээ, улсын комиссоор хүлээн авсан акт;

6.1.9. Хадгалах савны ашиглалтын паспорт;

6.1.10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;

6.2. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий, байгалийн хий түгээх станцын техникийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтыг /эх хувиар эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар/ бүрдүүлнэ. Үүнд:

6.2.1. Техникийн дүгнэлт гаргуулах хүсэлт;

6.2.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

6.2.3. Газрын тосны бүтээгдэхүүний түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;

6.2.4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулсан бичиг баримт;

6.2.5. Галын аюулгүй байдлын зөвшөөрөл;

6.2.6. Мэргэжлийн байгууллага боловсруулж улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших гэрчилгээ, улсын комиссоор хүлээн авсан акт;

6.2.7. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдын судалгаа;

6.2.8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ.

6.2.9. Хадгалах савны ашиглалтын паспорт;

Долоо. Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

7.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.1.1 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.1-т заасан хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;

7.1.2 Импортын талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу сар бүрийн 10-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;

7.1.3 Төрийн эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж ирүүлэх.

Найм. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

8.1 Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

8.1.1 Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж,

бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам"-ын дагуу компанийн нөөцийг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлэх;

8.1.2 Зориулалтын бус болон улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахгүй байх;

8.1.3 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээг тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэх;

8.1.4 Газрын тосны бүтээгдэхүүний агуулахад өргөтгөл хийх тохиолдолд тухай бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэх;

8.1.5 Бүх төрлийн шатахуун болон шингэрүүлсэн хий, байгалийн хийн бөөний борлуулалтын талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу дараа сар бүрийн 10-ны дотор, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн Мягмар гаригт эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;

8.1.6 Төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх ирүүлэх.

Ес. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

9.1 Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

9.1.1 Жижиглэнгийн худалдааны талаарх үнэн зөв мэдээллийг энэхүү журмаар батлагдсан маягтын дагуу дараа сар бүрийн 10-ны дотор, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн Мягмар гаригт эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;

9.1.2 газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээг тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэх;

9.1.3 Улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх;

9.1.4 Төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх;

9.1.5 Газрын тосны бүтээгдэхүүний худалдаанд хязгаарлалт хийсэн тохиолдолд энэ тухай 24 цагийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэх;

Арав. Тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

10.1 Журмын 7.1.3, 8.1.1, 9.1.3-д заасан мэдээ тайлангаа цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлээгүй, "Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний

болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам”-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

10.2 Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлэх нөхцөл арилсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

10.3 “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно.

10.4 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харъяа дүүргийн Татварын алба, холбогдох бусад байгууллагуудад бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Хяналт

10.5 Тусгай зөвшөөрлөөр олгосон үүргийн хэрэгжилтэд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцоно.

10.6 Хяналт тавих эрх бүхий байгууллагуудын төлөөллийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн объект, агуулах, түгээх станцад саадгүй нэвтрүүлж, үзлэг шалгалт хийх нөхцөл боломжоор хангана.

ооОоо